

УДК 37+398(470.47)

ЖАНГАР ТУУЛЬ ДАХЬ ХҮНИЙ ҮНЭЛЭМЖИЙН ТУХАЙ НЭГЭН АСУУДАЛ

В. Янжиндулам

PhD., Ховд их сургуулийн багш, Монгол улс

E-mail: yanjin victor@gmail.com

Товч хураангуй

Жангар тууль бол эрт үеийн монголчуудын үүх түүх, шүтлэг бишрэл, үнэт зүйлсийг хадгалан ирсэн хэл соёлын хосгүй нандин өв билээ. Аливаа ард түмний аман зохиол, хэл нь соёлыг мэдээлэх, угсаатан үндэстнүүдийн соёлын адил ба ялгаатай байдлыг илэрхийлэх хэмжүүр болно. Жангар туульд дайчин баатар эрс хүч чадал, цэц мэргэ, эрдэм ухаанаараа өрсөлдөн биесээ ялан дийлэхээс гадна хишиг буянаараа илүү төрсний учир ялан дийлэх нь бий. Монголчуудын дунд хүнийг үнэлэхдээ тэнгэрээс заяасан хишиг буянаар нь шинжин үзэж, хүнийг үнэлж байсан үнэлэмжийн нэгэн хэлбэр оршин байсныг Жангар туулийн жишээн дээр тодруулан үзлээ. Хүчтэй хүсэл эрмэлзэлтэй хүмүүс л ялах боломжтой. Эцсийн эцэст тэд зорилгодоо хүрэхийн тулд зөрүүд байдаг, саад бэрхшээл, эргэлзээгээр тэднийг эвдэж чадахгүй. Тэд хүчтэй зан чанар, ялах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэлтэй байдаг. Туульд ийм дайчид байдаг. Эдгээр нь жинхэнэ баатрууд юм. Тууль бидэнд тэсвэр хатуужил, аминч бус эр зоригийн тод жишээг өгдөг. Амьдралын хүнд хэцүү нөхцөл байдалд бууж өгөхгүй байхыг бид баатруудаас суралцдаг.

Түлхүүр үг

Жангар тууль, хишиг буян, үнэлэмж.

UDC 37+398(470.47)

ON THE QUESTION OF THE AXIOLOGY OF THE IMAGE OF MAN IN THE EPIC “DZHANGAR”

Yangindulam V.

PhD., Hovd University, Khovd, Mongolia

E-mail: yanjinvictor@gmail.com

Annotation

Jangar Tuul is a unique cultural heritage that preserves the history, worship and values of early Mongolians. The oral literature and language of any people can inform the culture and express the cultural similarities and differences of the ethnic groups. In Jangar epic, the warrior hero not only wins the competition with his strength, wisdom and knowledge, but also wins because he was born with more virtues. In the example of the Jangar poem, it was clarified that there was a form of appreciation among the Mongolians, who evaluated people based on their virtues given by heaven. Only those with a strong will can win. After all, they are stubborn to achieve their goals, obstacles and doubts cannot break them. They have a strong character, a will to win, and self-confidence. There are such warriors in epics. These are real heroes. The epic gives us vivid examples of endurance and selfless courage. We learn from heroes not to give up in difficult life situations.

УДИРТГАЛ

Оросын эрдэмтэн И.Е.Чучайкина, И.А.Акимова нар: «Соёл нь мэдээллийг үеэс үед дамжуулах, хадгалах үүрэгтэй ба мэдээлэл дамжуулах хоёр суваг байдаг. Түүний нэг нь уг гарвалын сан хөмрөг (генefонд), нөгөө нь янз бүрийн төрлийн текстэд буй ой санамж буюу дурсамжийн сан хөмрөг (мемefонд) юм» (Утга зохиол шинжлэл, 2006: 7) гэж тодорхойлоод соёлыг дамжуулдаг дээрх хоёр замын эхнийх нь бие махбодтой, хоёрдахь нь сэтгэл оюун санаатай холбогдоно. Гэтэл хэл нь уг гарвал ба санамж дурсамжийн аль алиных нь шинжийг агуулах тул тухайн ард түмний соёлын язгуур, эх сурвалж болдог гэж үзсэн байна. Үнэхээр ч хэл бол ертөнцийг танин мэдэх, эзэмших гол хэрэгсэл, аливаа соёлыг дамжуулах, хадгалах, түгээн дэлгэрүүлэх үндсэн хэрэглүүр болж байдаг учраас хэлийг тухайн үндэстнийх нь соёлоос салгаж үзэх боломжгүйн нэгэн адил тухайн соёлыг үндэстэн угсаатных нь хэлнээс салгаж ойлгох ямар ч боломжгүй (Омакаева, 1997). Бид энэ өгүүлэлдээ Жангар туульд “хишиг буян, заяа буян” хэмээх ухагдахуун ойлголт нь хүний хүчин чадлыг илтгэх хамгийн гол шалгуур үнэлэмж болж байгаа асуудлыг тодруулан авч үзнэ.

“Жангар” туульд дүрслэгдэж буй нэгэн өвөрмөц үзэл нь “илүү хишигтэй, заяатай” — төрсөн баатруудтай өрсөлдөгч дайсан этгээд нь хүч чадал, эр зориг, арга ухаанаараа илүү боловч хишиг нь дутсаны улмаас ялагдаж дийлдэх эсвэл хишиг буяныг шинжин мэдээд нэгдэж нөхөрлөж байгаагаар дүрсэлсэн байна. Үүнээс үзэхэд хүн болгон адил тэгш төрдөггүй эцэг тэнгэр хийгээд этүгэн эхийн ивээлээр бусдаасаа онцгой ид хүчтэй төрдөг гэсэн бөөгийн итгэл үнэмшилтэй холбогдож байна. “Жангар”-туульд хишигтэй төрсөн баатар эрс Тархай хожгор хүү, нусан журын дүрд хувирлаа ч хүч чадал, эр зориг, омог сүр нь хэвээр байж өрсөлдөгч дайсантайгаа тулалдсаар ялан дийлж байна. Баатар эрсийн эрэмгий хурдан хүлэг нь ч бас даль харцага үгүй даахьтай муу даага болж хувирсан ч хурдан гавшгай бэлгэ шинж нь биед нь оршин атаатан дайснаа ялан дийлж байна. Туулийн баатарт эр зориг, омог сүр, хишиг буян тэгш зохилдон төрснөөс хүч чадал нь дийлдэшгүй болж хүсэл зориг санаагаа гүйцээн нутаг орныг эзлэн дагуулж байна. Энэ талаар эрдэмтэн Т. Намжил Жангар тууль дахь бөх баатрын хүч чадал нь тэнгэрийн хүчтэй холбож үздэг буюу арга тал, эцэг эхээс буюу газар дэлхийгээс заяах билгийн тал гэсэн хоёр үүтгэлтэй хэмээн үзээд бөх баатар нь тэнгэрийн ба газрын хоёр талын хүчийг биедээ бүрэлдүүлж чадахгүй юм болбол тэрхүү бөх баатар нь бүрэн бүтэн хүчтэй болж чадахгүй гэж мэддэг байсан байдлыг тусгасан гэж үзжээ (Намжил, 2016: 143). Туулийн баатрууд атаа маргаа хийхдээ морь уралдуулж, бөх ноолдуулан, сур харвуулж эрхий мэргэн, эгэм далны хүч, хүлэг мориныхоо шандсыг сорьж эрдэм ухаанаараа цолгорсон баатар эр, зорьж очсон бүсгүйгээ гэргий болгон буулган авч байгааг үзүүлнэ. “Жангар” туульд

Тав орогч насандаа

Үеийн өнчин Жангарын хишиг

Бөх мөнгөн шигшрэгийн хүүгээс дээр болоод

Долоо орогч насандаа

Бүх орчлон дэлхийг гартаа авдаг хишигтэйг (Баянголын Жангар, III, 2015: 664)

Бөх мөнгөн Шигшрэг мэдээд энэ хүүг алаад тахиа нугас тэжээе гэхэд нь Хонгор түүнийг алуулахгүй түрүүлгээ хараад хэвтэж амь насыг авран үеийн үед үнэнч

нөхөрлөх болдог билээ. Халимаг Жангарт ч “Бөх мөнгөн Шигшрэг олзолж аваад, өөрийнхөө оронд байлгасан цагтаа шинжийн нарийнаар шинжлээд “Энэ наран доорхи амьтныг эзлэм их заяатай хүн болох юм” (Жангар, 2020: 47) — гэж шинжлээд Жангарыг хороохоор завдахад түүний хүү Хонгор дээр нь хэвтээд аминд нь хор хүргүүлдэггүй заяатай төрсөн Жангарыг хороох гэхэд нэг бол түүнийг хүмүүс авардаг эсвэл ид шидийн хүчээр өршөөгдөн тэмцэж буй байдал нь эгэл жирийн хүн болгонд байх шинж бус илүү хишигтэй онцгой заяатай нэгэнд бүрэлдсэн шинж юм.

“Мин гэгч уултай

Мянган түмэн албаттай

Газрын нэг өнцгийн

Ноён болоод байсан цагт минь

Эрхэн арван хоёр арслангаа дагуулж

Надтай байлдсанаа мэдэхүү та?

Гурван долоо хоног байлдаад

“Наран доорхийг эзлэм

Их хишигтэй хаан юм л!” гэж санаад

Мин гэгч уулаа хэрэггүй

Мянган түмэн албатаа хаяад

Цуутай цагаан авгайгаа хаяад

Цусан улаан охиноо хүргэнгүй орхиод

Алтан Шаргаараа ирж дагасан эс билүү би?

гээд Орчлонгийн сайхан Минъяан алтан шаргаараа ирж дагаж буй дүрслэл нь чухамдаа Жангарын бусдаасаа тэнгэрийн ивээлээр онцгой төрсөн шинжийг улам илүү тодруулж эртэй баатар эрсээр өөрийгөө хүрээлүүлж суух ховорхон хувьтайг илтгэнэ. Халимаг Жангарын Хонгорын гэрлэсэн бүлэгт Догшин Цагаан зул хааны Гэрэнзэлийг авахаар сүй тавьсан Малаацагаан бөхийг гурван маргаанд дийлэн гарахад Манхан богд өөрийн ачаа үхүүлээд “Богд ноён Жангар таны хишиг илүү санж, уулын нэгэн наран минь унав” (Жангар, 2020: 104) гэж Жангарын баатар сүр, тэнгэрлэг их хүчийг хүлээн зөвшөөрч байна.

Баянголын Жангар туульд Хонгорын хүү Хошуун эцгийнхээ өшөөг авахаар Бүргэд далай хааныд очихдоо хожгор тархай хүү болон модчин, дархан, хаш хийдэг ах дүү гурван дарханд очоод зарагдаж байхдаа үдийн халуунд толгой эх нь харанхуйлан муужран унахдаа “хишиг буянтай хүний хийлэнгээр толгойгоо ороохул гайгүй болдог билээ” (Баянголын Жангар, II, 2015: 317, 319) гээд кийлэнгээр нь толгойгоо цуглан эдгэж байгаагаар дүрсэлсэн байна. Хишигтэй хүний кийлэн цамц ч эдгээх хүч чадалтай төдийгүй кийлэнг нь нөмрөн суухдаа хишиг буян нь чухам юундаа байгааг шинжин олж, модчины зандан мод, дархны дөш, том ахын хаш толгойг нь сүйтгэн амны хишгийг нь алдуулж, амийг таслан атаатнаа дарж байгаагаар дүрсэлсэн байна. Хишигтэй хүний кийлэн цамцанд тухайн хүний илч дулаан, эрчим хүч хадгалагдан байдаг бөгөөд Хонгор, Жангар Хошуун нар зарим хатад ийм увдис чадалтай байна. Туульд өгүүлэхдээ тухайн хүний хишиг нь ямар нэгэн эд зүйлд агуулагдах бөгөөд түүнийг олж мэдэж чадсанаар атаатныг амар хялбар сөнөөж байна.

Хонгор Баянмөнх хааны хүүхнийг оройн үснээс тавгийн шар хальсан хүртэл шинжээд үзвэл “Биеэс нь долоон хувь доор хишигтэй, рид шид нь биеэс нь есөн хувь доор болж шинжлэгдээд” (Баянголын Жангар, I, 2015: 269) байдаг нь мордож байгаа бүсгүйг шинжээд хишиг буянгаар дорой доогуур болохыг мэдээд орхин одож байна.

Туульд эр зориг хүчин чадал төгөлдөр баатар эрийн хишиг буян ч үхэж мөхсөн хойноо ч хадгалагдан байгаагаар дүрсэлсэн байна.

Хишигтэй хүний толгойг

Богд ноён Жангарт хүргэж

Сүмэр уулын оройд тавина гэж

Малай хавхын толгойг

Ганзагалаад довтлоод хариад байдаг нь

Энэ болов уу гэнэ лээ (Баянголын Жангар, I, 2015 : 413) гэснээс үзэхэд эр зоригт, хишиг буян төгөлдөр атаат дайсныг толгойг уулын оройд хүндлэн тавих ёс уламжлал байжээ. Өнөө бидний үед сүргийн манлай хүлэг мориныхоо толгойг уулын орой, овоо хөтөлд тавих нь дээдлэн хүндлэх зан үйлийн илрэл болж үлджээ.

Хаан хүүхнийхээ

Хишиг буяныг авч

Хир зунгагийг нь авдаг гэж

Хаан хайхрав...

Хүүхний хумс хурууг нь аваад

Шагай чөмгөөр шүүс тавиад (Баянголын Жангар, I, 2015: 828) хамаг албатаа гэрт оруулж цайлдаг. Энэ өгүүлэмжид бэр болгон явуулах хүүхнийхээ хишиг буянг авч хоцрохын тулд хүүхнээ цайлан, хумсыг нь авч, шагай чөмгөөр шүүс тавьж илүүлж, албатаа гэрт оруулан цайлж байгаагаар дүрсэлсэн байна. Туульд хүүхнээ даган бүх албат нутаг нь даган одоход даллагын уут сав, бутангаар даллан дуудаад хагас нутгаа эргүүлж авлаа гэж дүрсэлсэн нь тохиолдоно.

Хүйтэн хар нүдээ тэлэн

Дөрвөн талаа харав

Наран суухын ар өнцөгт бариулсан

Гаслант Шил Гарьд байшин үзэгдэв

“Манай богд Жангарын байшинг бодвол

Ямар бол?” гээд харахад

Өргөндөө арал өргөн

Өндөртөө тэнгэрт тулам болох нь мэдэгдэв.

“Бас наран доорхийн нэг өнцгийг

Эзэлсэн **их хишигтэй амьтан юм.** Хэдийгээр Жангар хийгээд түүний баатруудын хүч чадал эр бяр нь илүү боловч Жангарын талаас илүү хишигтэй эсвэл эн тэнцүү хүч чадалтай хаад, баатрууд байгаа явдал бол Жангар болон шарын зургаан мянган арван хоёр баатарын хүчийг илүү хурцалж өрсөлдөгчтэй байж сайн хаан эсвэл эрэлхэг баатар болгож буй нь илт харагдана.

“Орчлонгийн сэлгээн байгаад

Олон бурхдын хайр байхлаар

Одоо чам дээр би эс гарах уу?”

гээд Хонгорыг яллан шийтгэсэн Айх Догшин Магнай хааны Бөх цагаан баатрыг үхлийн муугаар үхүүлээд, үе болгоны нь чавчиж хаяж байгаа дүрслэл нь чухамдаа л хишигтэй төрсөн хаан Жангар эрхэн зургаан мянган арван хоёр баатартайгаа эвлэлдэн байлдвал энэ наран доор дийлэхгүй дайсан байхгүйг нотолж байна. Гагцхүү хаан Жангар тэнгэрийн хишгээр хүчтэй эрэлхэг төрсөн ч ганцаараа бол хэзээ ч дөрвөн

тивийн хаан болж алдар цуугаа дуудуулж чадахгүй нь мэдээж харин арван хоёр арслан баатар нь “Хишиг, заятай”-төрсөн Жангарыг шинжилж мэдээд эх нутаг, элгэн садан, ээж аав, хайртай хатнаа хүртэл ганц биеэр нь орхиод ард нийтийг энхжингийн жаргалд умбуулах нэгэн үзүүрт сэтгэлийн эвийн хүчээр эвлэлдэн нэгдэж чаддаг.

Баатар Жилган хааны дараа суудаг
 Баруун талы нь ахлаж суусан
 Ирсэн зуун найман жилийн юмыг
 Тааж мэддэг
 Бадам зүрхэн гэдэг баатар:
 “Арслангийн Базаг Улаан Хонгорын хүч
 Баатар Хар Жилган хааны хүчнээс
 Долоон холбоон илүү боловч
 Хишиг нь долоон холбоо татуу
 Энэ хоёроор дүйцэж эвсэгтүн” гэв.
 Араг Улаан Хонгор хэлж байна:
 “Тэр үнэн болбол
 Би эвсэнэ.
 Баатар Хар Жилган хаан
 Юу зарлиг болгодгий нь хэмжье! гэхэд
 Баатар Хар Жилган хаан
 “Би ч өшөө барилгүй эвсэнэ” (Жанһр, 1990: 133) гэв.

Үүнээс үзэхэд хүч чадал илүү боловч хишиг буян нь эсрэг баатраас бага бол шууд хүлцэн, эвсэн найрамдаж байгаагаар дүрсэлсэн байна. Эрт үедээ хүний махан биеийн хүч чадлаас илүү тэнгэрээс өгсөн, далдын хүчнээс заяасан хишиг буянг илүүд үзэж байсан үнэлэмжийн нэгэн хэлбэр байжээ. Увжийн улаан Хонгор хүч ихтэй Шонхорын Бат мөнгөн Шигшилдэйтэй байр байлдсан бүлэгт Хий цөстэй Хүчит шонхор гэгч хаан Бат мөнгөн Шигшилдэй баатраа Жангараас Авай гэрэл хатан, Увжийн улаан Хонгор, билгийн хээр морийг нь авчруулахаар илгээдэг. Энэ үед Жангарт тунирхаад арван гурван жил унтаж байсан Хонгорыг сэрээж чадахгүй сандран тэвдэхдээ хатан Биндэрьяа нь “Билгийн хээр морийг минь аваад одов. Одоо энэ мангасын оронд явахул манай хишиг тасрав. Юун гэдэг муу ёр вэ” (Баянголын Жангар, II, 2015: 287) гэж хэлж эр нөхрөө сэрээж байна. Энэ өгүүлэмжээс харахад тухайн нутаг орны аз жаргалтай амьдралын хийморь сүлд хишиг буян нь баатар эрхийн хүлэг моринд байгаа гэсэн үзэл сэтгэлгээ бас илэрч байна.

Тууль дахь жишээнд тулгуурлан үзэхэд баатар эрсийг хүч чадал, омог сүр, эрдэм ухаан, оюун билиг, далдыг мэдрэх зөн совинтой зэрэг олон шинж чанарыг товойлгон дүрсэлснээс гадна хишиг буян, буян заяагаараа илт давуу төрсөн учир атаатан дайсан нь шинжин мэндээд анд нөхөд бололцох, ард олон, хүчит бодонгууд танин мэдсэнээр даган хүчээ өргөж байгаагаар дүрсэлсэн байна. Хүч чадал, эр зориг, эрдэм ухаанаас илүүтэй илүү хишиг буянтай, заяатай хүнийг хамгийн илүүд үздэг үнэлэмжийн хэлбэр нэгэнтээ оршиж байсныг туулиас харж болох байна.

Н о м з ү й

Баянголын Жангар (2015). I, II, III боть. Ерөнхий эрхлэн найруулагч Б. Мөнх, Д. Таяа нар. Хөх хот: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо.

Гуревич, П.С. (2004). *Соёл судлал*. Улаанбаатар: Адмон.

Жанһр. Хальмг баатрлг эпос (1990). Ясврнь Баснга Б.Б. урвдгч харцнь, Элст: Хальмг дегтр харһач.

Жангар (2020). Хөрвүүлсэн Т. Баясгалан. Улаанбаатар.

Намжил,Т. (2016). Жангар тууль дахь хүчний ойлголт ба бөх баатрын тухай өгүүлэмжийн учир. *Жангар судлал*. Ойрад судлалын цуврал. LXIV боть. Улаанбаатар.

Омакаева, Э. У. (1997). Текст как отражение картины мира: лингвокультурологические аспекты описания эпоса «Джангар». *Проблемы современного джангароведения*. Элиста: Калмыцкий государственный университет имени Б.Б. Городовикова. 26–31.

Утга зохиол шинжлэл (2006). Улаанбаатар.

References

Bayangolyn Zhangar (2015). I, II, III bot'. Erönkhij ehrkhlehn najruulagch B. Mönkh, D. Taya nar. Khèkh khot: Övør Mongolyn soyolyn khehvlehlijn khoroo.

Gurevich, P.S. (2004). *Soyol sudlal*. Ulaanbaatar: Admon (in Russian).

Namzhil, T. (2016). Zhangar tuul' dakh' khychnij ojlholt ba bèkh baatryn tukhaj ögyylehmzhijn uchir. *Zhangar sudlal*. Ojrad sudlalyn tsuvral. LXIV bot'. Ulaanbaatar.

Omaeva, E. U. (1997). Tekst kak otrazhenie kartiny mira: lingvokul'turologicheskie aspekty opisaniya eposa "Dzhangar". *Problemy sovremennogo dzhangarovedeniya*. Elista: Kalmytskij gosudarstvennyj universitet imeni B.B. Gorodovikova. 26–31 (in Russian).

Utga zokhiol shinzhlel (2006). Ulaanbaatar.

Zhangr. Khal'mg baatrлg epос (1990). Yasvrn' Basnga B.B. Gurvdgch hartsn', Elst: Khal'mg degtr gargach.

Zhangar (2020). Khörvүүлсэн Т. Bayasgalan. Ulaanbaatar.